



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/29/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 79

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ Ц.ЭНХТУЯА  
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006020130

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,172,320.00</b>	<b>23,172,763.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,082,920.00	23,172,763.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,082,920.00	23,172,763.00
35410	Бичиг хэргийн материал	64,280.00	27,640.00
35420	Аж ахуйн материал	14,703,540.00	14,703,540.00
35450	Барилгын засварын материал	-	28,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,315,100.00	8,413,583.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,143,106,627.29</b>	<b>1,090,906,802.92</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,143,106,627.29	1,090,906,802.92
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,120,326,627.29	1,067,376,802.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,073,773,353.28	1,073,773,353.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(95,819,235.72)	(126,578,853.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,849,930.00	78,849,930.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,200,273.73)	(35,409,801.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,345,678.98	57,345,678.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,251,825.52)	(23,232,504.28)
39217	Ном	42,629,000.00	42,629,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	22,780,000.00	23,530,000.04
39301	Програм хангамж	-	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(249,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	22,780,000.00	22,780,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,163,278,947.29</b>	<b>1,114,079,565.92</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,162,199,687.29</b>	<b>1,114,079,565.92</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,162,199,687.29	1,114,079,565.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,283,626,899.00	1,283,626,899.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(382,606,439.27)	(430,726,560.64)
51210	Өмнөх үеийн үр дүн	(382,606,439.27)	(382,606,439.27)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(48,120,121.37)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	261,179,227.56	261,179,227.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,163,278,947.29</b>	<b>1,114,079,565.92</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>308,748,343.26</b>	<b>204,557,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>107,805,543.26</b>	<b>4,311,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	107,719,043.26	1,311,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	107,719,043.26	1,311,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,226,500.00	1,311,300.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	12,000.00	3,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	12,000.00	3,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>200,942,800.00</b>	<b>200,246,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	18,280,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	18,280,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	14,808,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нооц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,808,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	200,942,800.00	167,157,000.00

**Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	190,942,800.00	167,157,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>267,139,544.16</b>	<b>252,677,821.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>267,139,544.16</b>	<b>252,677,821.37</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	265,440,706.56	251,861,116.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	109,234,416.86	101,422,426.00
210101	Үндсэн цалин	88,883,308.00	85,015,111.00
210102	Нэмэгдэл	16,523,228.86	13,363,315.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,827,880.00	3,044,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,597,197.39	13,913,906.46
210201	Тэтгэврийн даатгал	9,382,425.31	10,251,662.24
210202	Тэтгэмжийн даатгал	1,103,814.74	952,628.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	883,051.78	831,004.59
210204	Ажилгүйдлийн даатгал	196,817.36	165,002.29
210205	Эрүүл мэндийн даатгал	2,031,088.20	1,713,608.88
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,867,839.15	63,828,653.00
210301	Гэрэл, цахилгаан	936,137.15	982,443.00
210302	Түлш, халаалт	61,749,600.00	54,150,300.00
210303	Цэвэр, бохир ус	1,182,102.00	8,695,910.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,163,295.00	1,581,910.00
210401	Бичиг хэрэг	632,570.00	1,323,260.00
210402	Тээвэр, шатахуун	27,825.00	25,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	80,500.00	120,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	43,650.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	627,850.00	7,461,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	122,350.00	80,000.00
210604	Урсгал засвар	505,500.00	7,381,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	33,818,920.00	10,453,397.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,624,170.00	10,453,397.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	43,083,738.16	53,199,824.37
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,083,738.16	53,199,824.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,698,837.60	816,704.54
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,000.00	150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	150,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	666,704.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	666,704.54
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>41,608,799.10</b>	<b>(48,120,121.37)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(21,018,580.90)</b>	<b>(48,120,121.37)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,283,626,899.00	261,179,227.56	(382,606,439.27)		1,162,199,687.29
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,283,626,899.00	261,179,227.56	(382,606,439.27)	-	1,162,199,687.29
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,283,626,899.00	261,179,227.56	(382,606,439.27)	-	1,162,199,687.29
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,283,626,899.00	261,179,227.56	(382,606,439.27)	-	1,162,199,687.29

**Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,283,626,899.00	261,179,227.56	(382,606,439.27)	-	1,162,199,687.29
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(48,120,121.37)		(48,120,121.37)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,283,626,899.00	261,179,227.56	(430,726,560.64)	-	1,114,079,565.92

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>235,243,800.00</b>	<b>202,647,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,301,000.00</b>	<b>1,311,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	34,226,500.00	1,311,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,226,500.00	1,311,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,226,500.00	1,311,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>200,942,800.00</b>	<b>201,335,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	18,280,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	18,280,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	15,897,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	9,808,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,089,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	200,942,800.00	167,157,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	190,942,800.00	167,157,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>224,919,300.00</b>	<b>201,647,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>224,919,300.00</b>	<b>201,647,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>222,131,062.40</b>	<b>200,786,745.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	109,148,119.00	102,509,070.22
210101	Үндсэн цалин	86,535,408.00	83,865,206.22
210102	Нэмэгдэл	18,620,411.00	15,063,864.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,992,300.00	3,580,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	13,599,009.25	13,837,620.24
210201	Тэтгэврийн даатгал	9,323,837.94	9,874,902.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,091,733.87	1,010,845.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	873,187.08	808,672.78
210204	Ажилгүйдлийн даатгал	217,561.48	194,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,092,688.88	1,948,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	63,867,839.15	63,767,055.00
210301	Гэрэл, цахилгаан	936,137.15	982,443.00
210302	Түлш, халаалт	61,749,600.00	61,738,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,182,102.00	1,046,112.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	477,425.00	407,200.00
210401	Бичиг хэрэг	252,000.00	102,200.00
210402	Тээвэр, шатахуун	27,825.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	128,400.00	100,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	105,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	618,500.00	7,599,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	80,000.00
210604	Урсгал засвар	518,500.00	7,519,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	34,350,570.00	12,666,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,155,820.00	12,666,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,788,237.60</b>	<b>860,354.54</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,000.00	193,650.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	193,650.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	666,704.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	666,704.54

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,324,500.00	1,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,250,000.00	1,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,250,000.00	1,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,250,000.00	1,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,250,000.00	1,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,250,000.00)	(1,000,000.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

### ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	0.00	178459436.27	195846500.00	191570462.40
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	0.00	178459436.27	195846500.00	190370462.40
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	0.00	178089436.27	195746500.00	190270462.40
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.00	95676235.00	112550700.00	109148119.00
210101	Үндсэн цалин	0.00	89509904.00	86362500.00	86535408.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00	19200900.00	18620411.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	6166331.00	6987300.00	3992300.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.00	11598993.27	13694500.00	13599009.25
210201	Тэтгэврийн даатгал	0.00	7960935.47	9324400.00	9323837.94
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	800778.64	1092500.00	1091733.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	784056.32	874000.00	873187.08
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	183906.70	218500.00	217561.48
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	1869316.14	2185100.00	2092688.88
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	0.00	65049168.00	64634700.00	63867839.15
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1376826.00	1100000.00	936137.15
210302	Түлш, халаалт	0.00	61749600.00	61734700.00	61749600.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	1922742.00	1800000.00	1182102.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	458400.00	573900.00	477425.00
210401	Бичиг хэрэг	0.00	112000.00	252200.00	252000.00
210402	Тээвэр, шагахуун	0.00	125900.00	112500.00	27825.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	151,300.00	140,000.00	128,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	69,200.00	69,200.00	69,200.00
2105	<b>Нормативт зардал</b>	-	69,600.00	69,600.00	69,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	69,600.00	69,600.00	69,600.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	679,000.00	619,000.00	618,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	160,000.00	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	-	519,000.00	519,000.00	518,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	4,439,840.00	3,604,100.00	2,489,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,196,000.00	3,496,100.00	2,295,220.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	130,000.00	108,000.00	108,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	370,000.00	100,000.00	100,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	370,000.00	100,000.00	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	370,000.00	100,000.00	100,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	180,215,200.00	191,805,683.00	193,169,300.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	188,908,683.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	188,908,683.00	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	6,685,400.00	2,897,000.00	2,226,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	2,897,000.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>14,808,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>14,808,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	14,808,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	7,000,000.00
210604	Урсгал засвар	-	7,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	7,808,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	7,808,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>1,089,400.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,089,400.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Булган сумын Соёлын төв нь “Таатай орчин, чадварлаг баг, чанартай үйлчилгээ” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд үйл ажиллагааны чиглэл нь “Загвар соёлын ордон болох” зорилтыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 329.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Мян.төг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			

Авлага	1089.4	0	1089.4
Бараа материал	19082.9	23172.7	-4089.8
Үндсэн хөрөнгө	1275377.9	1276377.9	-1000.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1163278.9</b>	<b>1114079.5</b>	<b>49199.4</b>
<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Хуримтлагдсан үр дүн	-382606.4	-169547.3	-213059.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1163278.9</b>	<b>1114079.5</b>	<b>49199.4</b>

**Авлага:** Тайлант онд эхний үлдэгдэл 1089.4 мянган төгрөг, жилийн эцсийн үлдэгдэлгүй тайлант онд авлагыг барагдуулж ажилласан байна.

**Бараа материал:** Оны эхний үлдэгдэл 19082.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 23172.7 мянган төгрөг болж өмнөх оноос 4089.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 12721.03 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 8631.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1275377.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1276377.9 мянган төгрөг болж өмнөх оноос 1000.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1000.0 мянган төгрөгийн программ шинэчлэл нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Өглөгийн дансанд оны эхний үлдэгдэл 1079.2 мянган төгрөг байсныг тайлант онд барагдуулж эцсийн үлдэгдэлгүй байна.

Санхүү байдлын, Үр дүнгийн, Мөнгөн гүйлгээний, Өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын Соёлын төв нь 2021 онд орон нутгийн төсвөөс 207.6 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Булган сумын Соёлын төв нь 2021 он нэмэлт дансаар 14.8, орон нутгийн төсвөөс 190,3 сая төгрөг буюу нийт 206.2 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 204.6 сая төгрөгийг зарцуулж 0.6 сая төгрөгийн хэмнэлттэйгээр тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган сумын Соёлын төв нь 2021 онд нэмэлт дансаар нийт 14.8 сая төгрөгийн санхүүжилт авснаас дээврийн урсгал зардалд 7.0, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 7.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Булган сумын Соёлын төв нь 2021 онд бороо, цасны ус гоожиж байсан дээврийг 7.0 сая төгрөгөөр засвар хийлгэсэн байна. Мөн 2019 онд Швейцарын хөгжлийн агентлагаас кино хийх төслөөс үлдсэн үлдэгдэл 1.08, дээд шатны төсвийн захирагчаас Ж.Гүррагчаагийн нэрэмжит хүүхдийн уралдаан соёл урлагийн үйл ажиллагаа зохион байгуулахаар 2.3, аймгийн Засаг даргын нөөцөөс Соёлын ордон үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд 0.5 сая төгрөгийн орлого орсон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 6 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор дотоод хяналтыг зохион байгуулж ажилласан байна. Үүнд:

- Ажилчдын цаг тандалт болон албаны хувцаслалтад тандалт хийх
- Соёл болон түмний ажилд хяналт тавих
- Цар тахалтай холбоотой Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих
- Байгууллагын 00 болон ариун цэврийн байдалд хяналт тавих
- Байгууллагын өмч хамгаалал, эд хөрөнгөнд шалгалт хийж эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолж эд хөрөнгийн бүртгэлтэй тулгах зэрэг дотоод хяналтыг зохион байгуулж ажилласан байна.

Соёлын төвийн хувьд 10.5 орон тоогоор ажиллаж байна. Орон тоог 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн Б/01 тушаалаар орон тоог баталсан байна.

Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг зөрчсөн ажил гүйлгээ хийгээгүй байна.

Санхүүгийн тайлантай холбоотой үндсэн хөрөнгө болон бараа материалын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, орлого үр дүнгийн тайлангийн уядлаа холбоотой залруулах бичилт хийлээ. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотойгоор нярвын тайлангийн баримтын бүрдэл хангалтгүй, тамга тэмдэг, гарын үсэг дутуу байна. Шилэн дансанд нийт 151 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг албан шаардлага өгч ажилласан.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн боловч 2021 оны "Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр), "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр)" "Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)" мэдээг хугацаанд нь мэдээлээгүй, хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа ч хугацаа хоцроож мэдээлсэн нь холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг албан бичгээр хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүртгэл буюу нярвын тайлангийн анхан шатны баримтын бүрдэл дээр анхаарах, шилэн дансны мэдээг хугацаа хоцроолгүй мэдээлэхэд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3 алдаа зөрчил илэрснээс, 2 албан шаардлага, 1 залруулаг хийж ажиллалаа.

### 4.1 Санхүүгийн тайлантай холбоотой залруулаг

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тайлан, бараа материалын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, орлого үр дүнгийн тайлангийн уялдаа холбоо, бичилтийг залруулсан.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй.

### 4.3 Анхан шатны баримттай холбоотой албан шаардлага

4.3.1 Нярвын баримтын бүрдэл дутуу, хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

### 4.3.2 Шилэн данстай холбоотой албан шаардлага

Нийт 151 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээ хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/сая/төгрөгөөр/							
				Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Булган сумын Соёлын төв	3	0	1	0	0	0	2	0	0	0